

ТАНИЛЦУУЛГА/ дэлгэрэнгүй/

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.13 дахь заалтад зааснаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар албан бус байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээхийг төрийн албан хаагчдын хориглодог боловч тус зүйлийн тайлбарт зааснаар энэ улс төрийн албан хаагчдад хамаарахгүй байхаар хуульчилсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд нэгдсэн болон Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлж хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль тогтоомжийн төсөл, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй.” гэж заасан байдаг.

Дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд улс төрийн албан хаагч нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар албаны болон албан бус байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээх түгээмэл бөгөөд энэхүү үйл ажиллагааг төлбөртэйгээр идэвхжүүлэн түгээх, зарим тохиолдолд төрийн байгууллагын нийгмийн сүлжээний цахим хуудасыг ашиглах явдал нэлээдгүй гарч байна.

Энэ төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгож, олон нийтэд тайлагнах гэхээсээ илүүтэйгээр хувь хүний сурталчилгаа, зарим тохиолдолд улс төрийн зорилгоор хуурамч мэдээллийг түгээж олон нийтийг төөрөгдүүлж иргэдийн мэдэх эрхийг зөрчих, улс төрийн шударга бус өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна.

Meta Ad Library Report-д дурдсанаар 2020 оны 8 дугаар сараас нийгэм, улс төр, сонгуультай холбоотой 56906¹ төлбөртэй сурталчилгаа фэйсбүүк платформ оруулж, \$2,238,838 буюу ₮8 тэрбумыг төлсөн байна.

Иймд Төрийн албаны тухай хуульд Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшиж хуулиар зөвшөөрөгдсөн сурталчилгааны хугацаанд болон гэмт хэрэг, зөрчил, гамшигаас хамгаалахаас бусад тохиолдолд өөрийн нийгмийн сүлжээнд оруулсан контент, мэдээ, мэдээллээ төлбөртэйгээр идэвхжүүлэн түгээхгүй байх, энэ

¹ 2026 оны 3 дугаар сарын 22-ны өдөр сүүлд нэвтрэв.

зорилгоор төрийн байгууллагын нийгмийн сүлжээний цахим хуудасыг ашиглахгүй байхаар тусгана.

Хуулийн төсөл батлагдснаар төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, олон нийтэд төрийн байгууллагын үйл ажиллагааг тайлагнах ажилагааг улс төрийн зорилгоор ашиглахгүй байхад түлхэц болно. Түүнчлэн улс төрийн зорилгоор хуурамч мэдээлэл түгээж олон нийтийг төөрөгдүүлж иргэдийн мэдэх эрхийг зөрчих, иргэдийн шийдвэр гаргах байдалд зохисгүй байдлаар нөлөөлөх, улс төрийн шударга бус өрсөлдөөнийг хязгаарлана.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулж, олон нийтээс саналыг авлаа.

----o0o----